



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/ВЧ

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.14, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Газрын албан хаагчдын албан хэрэгцээнд хэрэглэгдэх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны гутал хэрэгслээр хангах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны гутал хэрэглэлд зарцуулагдах 4,900,000 (Дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийг хөдөлмөр хамгааллын зардлаас гаргахыг агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Худалдан авсан хөдөлмөр хамгааллын гутал хэрэгслийг албан хаагчдад актаар хүлээлгэн өгөх, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ